



**СЭЛЭНГЭ АЙМАГ
ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 8/74

Жаргалант

**Бүх нийтийн хог цэвэрлэгээг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-в, Монгол Улсын Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5, Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дугаар зүйл, аймгийн Засаг даргын 2019 оны “Хоггүй цэвэрхэн Сэлэнгэ” А/308 тоот захирамжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Бүх нийтийн их цэвэрлэгээний ажил зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар баталж, тусгай удирдамж, төлөвлөгөө хуваарь гаргаж үр дүнтэй сайн зохион байгуулж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

2. Бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулах ажлын хүрээнд сумын төвийн гудамж талбай, нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг цэвэрлэж тохижуулж идэвхтэй оролцож ажиллахыг сумын нийт иргэд, албан газар, аж ахуйн нэгж, байгууллага, дарга, эрхлэгч, захирал наарт үүрэг болгосугай.

3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, Багийн Засаг дарга наарт **ДААЛГАХ** нь:

а/Хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулалттай шуурхай явуулахын тулд иргэн бүр ажлын багаж хэрэгслийн бүрэн бэлтгэл ханган ажиллаж нийтийн эзэмшлийн газрыг өнгө үзэмжтэй болгох

б/Цэвэрлэсэн хогийг ачуулж тогтоосон хогийн цэгт хүргэж хийсч бутрахаас хамгаалан дарж булах ажлыг зохион байгуулах

в/Гэр хороолол гудамжны хооронд цэвэрлэх талбайг иргэд, аж ахуйн нэгжүүдэд зааж өгөх, хог хаягдлыг дундаа орхигдуулахгүй бүрэн гүйцэд цэвэрлэх

г/Нийтийн хог цэвэрлэгээний ажил явагдаж байгаатай холбогдуулан суманд үйл ажиллагаа явуулж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дарга, эрхлэгч нар ажилтан, албан хаагч нарыг бүрэн хамруулж ажиллах

4. Сумын хэмжээнд зохиогдож байгаа их цэвэрлэгээний ажилд оролцоогүй, захирамжинд заагдсан холбогдох арга хэмжээг зохион байгуулаагүй иргэд, хэсгийн ахлагч, аж ахуйн нэгжийн удирдлагууд, албан байгууллагын захирал, эрхлэгч наарт